



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэрийн, нийт 56,548,609.26 (тавин зургаан сая таван зуун дөчин найман мянга зургаан зуун есөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 56,412,329.76 (тавин зургаан сая дөрвөн зуун арван хоёр мянга гурван зуун хорин есөн төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс төмрийн хаягдлыг ялган тоолж “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанид тушаах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Өвөлжөөний доорх газрын эзэмших эрхийг компанийн мэдэлд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005562  
17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар  
2023 оны 06 дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Насос СД-160/45	3/28/2003	1	ш	1,884,680.00	1,884,680.00	0.00
2	Халаах гадаргуу өрлөг дулаалга К4	12/19/2006	1	ш	51,711,382.00	51,711,382.00	0.00
3	Трансформатор 160кВа /АТП-1/	1/1/1984	1	ш	569,000.00	569,000.00	0.00
4	Шит КНС	10/12/2007	1	ш	560,000.00	560,000.00	0.00
5	А3 өнгөт принтер	12/31/2017	1	ш	1,000,000.00	1,000,000.00	0.00
6	Факс	12/31/2013	1	ш	142,150.00	142,150.00	0.00
7	Өвөлжөө /хаалгатад/	1/1/2006	1	ш	681,397.26	545,117.76	136,279.50
			7		56,548,609.26	56,412,329.76	136,279.50
	Нийт дүн		(долоо)		(тавин зургаан сая таван зуун дөчин найман мянга зургаан зуун есөн төгрөг хорин зургаан мөнгө)	(тавин зургаан сая дөрвөн зуун арван хоёр мянга гурван зуун хорин есөн төгрөг далан зургаан мөнгө)	(нэг зуун гучин зургаан мянга хоёр зуун далан есөн төгрөг тавин мөнгө)